

МОНГОЛЫН НУУЦ ТОВЧООНД ТУСГАГДСАН ЦЭРГИЙН ГУРВАН НЭР ТОМЪЁОНЫ ТУХАЙД

Ж.Базарсүрэн

Товч утга: Монголын нууц товчоо бол дундад эртний монгол цэргийн түүхийн судалгааны гол тулгуур бичиг. Хэдийгээр хэл шинжлэлийн үүднээс нөр их судалгааны ажил хийгдэж, чамгүй ололт амжилттай байгаа авч тусгай мэргэжлийн, түүний дотор цэргийн хэргийн холбогдолтой цөөнгүй үг хэллэг, нэр томъёо, ухагдахуун судалгаа шинжилгээ, оновчтой тайлал, тайлбараа хүлээсээр байна. Түүний жишээ нь “Алгинчлах” буюу “Байлдан тагнах”, монголын эртний цэргийн “Нуур байр” хэмээх “Байлдааны журам”, мөн “Үйлсэн хор” хэмээх нэгэн зүйл сумын талаарх тайлбар юм. Тэдгээрийн тухайд олон судлаач өөр өөр тайлбар хийсээр байгааг цэргийн хэргийн талаас нь нягталж нэг мөр болгох хэрэгтэй байна.

Түлхүүр үг: Монголын нууц товчоо, манлай, алгинч, алгинчлах, нуур байр, хоромсого, үйлсэн хор, байлдааны журам, байлдан тагнах

Оршил

Дайн хэмээх онцгой үзэгдэл хүн төрөлхтний амьдралын салшгүй хэсэг байсаар өдийг хүрсэнчлэн монголчуудын түүхийг ч цэрэг, дайнаас ангид үзэх арга үгүй. Тэр тусмаа

“Одтой тэнгэр орчиж
Олон улс байлдаж
Орондоо унтах завгүй
Олзлолдон булаалдаж байв”¹

хэмээн “Монголын нууц товчоо” (чанагш МНТ гэж товчлов)-нд өгүүлсэн тэр үеийн түүх бараг бүхэлдээ цэрэг дайны түүх гэвээс дэгсдэхгүй. Тиймээс дундад эртний үеийн монголчуудын цэргийн түүхийн судалгааны гол тулгуур сурвалж бичиг нь Их Монгол Улсын энэхүү их нэвтэрхий шастир бөгөөд түүнд “Цэргийн байгуулалт”, “Цэргийн хууль цааз”, “Дайн байлдааны түүх”, “Цэргийн урлагийн түүх зэрэг Цэргийн түүхийн ухааныг бүрдүүлэгч бүхий л салбар хэсэгт хамаарах түүхэн баримтууд агуулагдаж буй.

¹ Ц.Дамдинсүрэн. (Хуучин монгол хэлнээс одоогийн монгол хэлээр орчуулсан орчуулга), Улаанбаатар, 1990, § 254.

Тодруулваас Чингис хаан “Цэрэг үүсгэсэн” хийгээд цэргийн эрс шинэчлэл хийж монгол цэргийн “Хүрээний байгуулалт”-ыг халж аравтын тогтолцоонд үндэслэсэн “Мянгатын байгуулалт”-ад шилжүүлэн гадаад 95 мянган, эртний “Турхаг” цэргийн уламжлалд тулгуурлан байнгын цэрэг болох “Хэшигтэн” хэмээх цэрэг-захиргааны өвөрмөц үүрэг бүхий институтыг байгуулсан зэрэг “Цэргийн байгуулалт”-тай холбоотой, бас цэргийн удирдлага, хууль цаазтай холбоотой олон чухал баримт бий. **“Хор агсах”, “Илд агсах”, “Хорчин”, “Турхаг”, “Хэвтүүл”, “Хүрээ”, “Аравт”, “Зуут”, “Мянгат”, “Түмт”, “Туластан цэрэг”**-ээс авахуулаад монгол цэргийн **“Аяны журам”, “Байлдааны журам”**-ыг бүрдүүлэгч **“Суурин харуул”, “Алгинч”, “Манлай”, “Их гол”, баруун зүүн гарын “Хайгуул”, арын “Цагдуул буюу цагдуулсан”, “Харуул”, “Хөтөд”** гэх мэт цэргийн зохион байгуулалттай холбоотой олон нэр томъёо агуулагдаж байна.

МНТ-ны 282 зүйлийн 103-т буюу 36,5 %-д том жижиг зэвсэгт мөргөлдөөн, дайн байлдааны тухай мэдээлэл багтжээ. Тухайлбал: Чингис хааны дээд үе (Бодончараас Есүхэй баатрын үе)-д хамаарах **17 удаагийн** (§39,58,59,177) байлдааны мэдээ, Таргудай Хирилтуг тэргүүтэн тайчууд халдан ирж Тэмүүжинийг баривчлан авч одсоноос эхлэн Их Монгол Улсыг байгуулахын өмнөх үеийн буюу байгуулах явцад хамаарах **33 зэвсэгт мөргөлдөөн, байлдаан, тулалдааны тухай** (§79, 90-91, 98-102, 104-110, 129, 133, 136, 141-143, 144, 150, 153, 154, 157, 158, 162, 163, 170-171, 177, 185, 193-196, 197, 198, 199, 202, 208, 235, 236,237, 239, 240) болон **Хятад, Тангуд, Сартаултай хийсэн дайн**, мөн МНТ-нд **“Хибчагийн аян”** хэмээн нэрийдэж буй Бат хаан тэргүүтэн ахмад хөвгүүд өрнө зүгт аялан дайлсан түүхэн үйл явдалтай холбогдох (§247-254, 257-264, 265-268, 270, 272-273, 274-277) олон тооны мэдээлэл оржээ.

Зэр зэвсэг л гэхэд нум сум, илд, жад, хутга мäs, халх бамбай зэрэг **10 шахам төрөлд хамаарах “дөрү жад”, “сумч хутга”, “алангир нум”, “үйсэн хор”, “хатангу дээл”** гэх мэт **34 зүйл зэвсгийн** нэр томъёо агуулагдаж байна.

Мөн **“Өдөх буюу өдөж хөдөлгөх”, “Алгинчлах”, “Огжатгах”, “Харгана зорчил зорчих”, “Нуур байрт байлдах”, “Цүүц хатгаа хатгах”, “Нохой хэрэл хэрэх”, “Дэрэлгэх”, “Тойрох”, “Өлөмлөх”, “Шивээлэх”, “Хороолох”, “Орчих буюу бүслэх”, “Нүүр дээрээс асгах”** зэрэг цэргийн тактикийн олон өвөрмөц аргын талаар өөр хаанаас үл олдох чухал мэдээллийг МНТ бидэнд өгч байна.

Тэр бүхнийг эс өгүүлэн өгүүлэх нь:

1.”Алгинчлах” буюу “Байлдан тагнахуй”

МНТ-ны §195 -д Чингис хаан Найманы цэрэгтэй Наху хун (Одоогийн Булган аймгийн Дашинчилэн сумын нутагт орших Лаху баян уул)-д тулалдсан тухай дурдсан хэсгээс л гэхэд эртний монгол цэргийн байлдааны журмын нэгэн хувилбарын талаар нэлээд тодорхой мэдээлэл авч болно. Тэнд өгүүлснийг үзвээс Чингис хаан тэр байлдаанд цэргээ **“Манлай”, “Их гол”, “Хөтөд”** хэмээх гурван үндсэн хэсэгт хувааж тулалдсан байх бөгөөд тэр хэсэг тус бүр нь мөн хэд хэдэн цувраанаас бүрдэл болж байжээ. **“Манлай”** буюу их цэргийн тэргүүн хэсэгт Зэв, Хубилай, Зэлмэ, Сүбээдэй нарын цэрэг нэгдүгээр цувраа болж, тэдний араас

хоёрдугаар цувраа болох Урууд, Мангудын цэрэг фронтын хоёр жигүүрээр ороож тойрон

“Эхэ-юүгэн хорчин торолун

Гүйикү унугад мэтү”

(Эх юүгээн орчин тойрон

Гүйх унагад мэт)² довтолж, тэдний араас манлайн гуравдугаар цувраанд Чингис хаан “өөсөөн алгинчилжээ”.

“Алгинчлах” гэдгийг МНТ-ны хятад хадмалд “Түрүү харуул” гэж утгачилан тайлбарласан ба хэл шинжээчид “1. Тагнах, тандаж турших; 2. Цэргийн түрүүнд манлайлан явах” тайлжээ³. МНТ-нд өгүүлснийг үзвэл алгинчийг үнэхээр ч цэргийн түрүүнд буюу манлайд, аян замд бол бүр манлай цэргээсээ ч түрүүлүүлэн илгээдэг байжээ.

Энд дуртган буй Наху хуны байлдаанд Чингис хаан өөрийн биеэр алгинчлахдаа манлайн гуравдугаар цувраанд орж тулалдсаныг дээр өгүүлсэн. Уул нь тэр үед монгол цэргийн жанжнууд ихэвчлэн байлдаанд түрүүлж ордоггүй, харин гол хүчний дотор юмуу ар талд байрлан байлдааныг удирддаг байсан байдаг. Энэ нь хэрвээ жанжнууд байлдаанд түрүүлж ороод амь эрсдвэл цэрэг удирдлагагүй болж ялагдал хүлээхээс сэргийлсэн хэрэг байсан ба тийм учраас одоо ч гэсэн аль ч улсын цэргийн удирдлага тэргүүн эгнээнд байрладаггүй. Гэтэл Чингис хаан тэрхүү байлдаанд яагаад манлайд орж байлдах шийдвэр гаргав гэдэг асуудал зүй ёсоор гарч ирж байгаа юм. Учрыг тунгааваас Найманы цэрэг хүн хүчний хувьд үлэмж давуу байсныг Чингис хаан гадарлаж байсан авч яг таг багцаа байгаагүй агаад тэдний байлдааны журам ч тодорхой мэдэгдэхгүй байсан, тухайлбал хаа хаана, ямар ямар хүч хэрэгсэл байрлаж, ямар арга тактикаар байлдах гэж буй нь мэдэгдэхгүй байсан учраас тийм шийдвэр гаргасан гэсэн дүгнэлт хийж болохоор байгаа юм. Цэргийн ямар ч жанжин дайсныхаа тухай тодорхой мэдээлэлгүйгээр мухар сохроор тулалдаан явуулдаггүй. Тэгвээс сохор аз л таардаггүй юм бол гарцаагүй ялагдалд хүрдэг жамтай. Тиймээс үхэх, сэхэхийг шийдвэрлэхээс гадна монгол туургатныг нэгтгэх их үйлсийн хамгийн сүүлчийн гэж болох их сорил шалгуур болсон тэрхүү байлдааныг эхлэхдээ Чингис хаан өөрөө алгинчлах буюу дайсны байр байдлыг байлдааны эхэнд өөрийн биеэр тандан мэдэх зорилго тавьсан нь тодорхой байна. Чингэхдээ гол хүчээ Хасараар захируулсан нь байлдааныг бүхэлд нь түүгээр удирдуулсан гэсэн хэрэг огт биш гэдэг нь ч байлдааны цаашдын ажиллагаанаас ойлгогдож байгаа юм.

Тэгвэл орчин үеийн цэргийн шинжлэх ухаанд “Байлдан тагнах” гэдэг ойлголт байдаг. Тэр нь дээрхийн нэгэн адил дайсан этгээдийн хүчин чадавх, байр байдал, хүч хэрэгслийн байршил, цувраажилт тодорхой мэдэгдэхгүй байгаа нөхцөлд түүнийг тандан мэдэх зорилгоор байлдааны жинхэнэ буюу гол ажиллагаа эхлэхээс өмнө тодорхой (багахан) хүчээр “хуурамч” байлдаан хийхийг хэлдэг. Энэхүү “Байлдан тагнах аргыг анхлан 1942 оноос эхлэн Зөвлөлтийн цэрэг өргөн хэрэглэх болсон”⁴ гэж цэргийн мэргэжилтнүүд үзсээр ирсэн билээ. Тактикийн эл аргыг одоо ч олон улсын цэрэгт хэрэглэсээр байгаа.

² Б.Сумъяабаатар. Монголын нууц товчоо. Үсгийн галиг, Улаанбаатар, 1990, §195.

³ Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. (Таван боть). I. (А-Г). Улаанбаатар, 2008, т.67.

⁴ Военный энциклопедический словарь. Москва. 1983. стр.547

Гэтэл “Байлдан тагнах” аргын уугал хувилбарыг Чингис хаан бүр 1204 онд буюу түүнээс 738 жилийн өмнө хэрэглэж байсныг Монголын нууц товчоо тэргүүтэн сурвалжууд нотолж байна. Тэгэхээр байлдаанд “Алгинчлах” буюу одоогийн цэргийн хэллэгээр “Байлдан тагнах” арга нь Чингис хаанаас дэлхий дахины цэргийн урлагт оруулсан их хувь нэмрийн нэгээхэн зүйл гэж ойлгож болно гэж бодном.

2. “Нуур байр” – Байлдааны өвөрмөц журам

Наху хуны байлдааныг эхлэхийн өмнө Чингис хаан тулалдах арга мэхээ тодорхойлохдоо тактикийн гурван аргыг тэр үеийн оноосон нэрээр нь цохон дурдсан байна. МНТ-ны хятад хадмалын утгыг нь Э.Хэниш “Нуур маягийн тэмцэл хийх арга” гэж тайлсан тахикийн аргыг судлаачид “На’ур байилду’а байилдужу”, “На’ур байду байилдужу”, “наур байду байлдужу”, “На’ур байи [л] ду байилдужу” гэх мэтээр олон янзаар сэргээснийг Ш.Гаадамба гуай “Хятад галигт ...”байиду” гэж ташаа тэмдэглэсэн болов уу гэж бодож байна” гээд “... Дамдинсүрэн “нуур байрлалаар байрлаж” гэж зөв болгожээ. Энэ үгийн утгыг бид “нуур мэт өргөн дэлгэр байр эзлэн дайсан этгээдэд их цэрэг байгаа мэт сүр үзүүлэх гэсэн бололтой” гэж тайлбарлажээ⁵. Академич Д.Цэрэнсодном “Нуурын байдлаар байрлаж” гэж буюу “Нуурын байдал” гэж сэргээсэн буй⁶.

Үүнтэй холбогдуулан өгүүлэхэд эртний монгол цэрэгт “**Байр**” буюу “**Байр хийх**” гэдэг нэгэн ойлголт бий. Тухайлбал: монгол цэрэг дайсантайгаа тулгарах үед шууд л уухай хашгиран бөөнөөрөө эмх замбараагүй тулалддаггүй, харин байлдааны цагийн байдал буюу дайсныхаа болон өөрийнхөө хүн хүчнийхээ тоо хэмжээ, цэрэг зэвсгийн чадавх, тухайн газар орон хийгээд цаг улирлын онцлог нөхцөлд тохируулан байлдах арга мэхээ шигшин сонгодог. Тэгээд тулалдааныг эхлэхийн өмнө аравт, зуут, мянгат буюу анги, баг, цуваа, эгнээ бүрийн байлдаанд гүйцэтгэх үүрэгт нь зохицуулан хүч хэрэгслээ бүлэглэн хувааж цувраажуулаад, тус бүрийг нь дөрвөлжин, гурвалжин, нуман гэх мэт төрөл бүрийн хэлбэртэйгээр жагсаан байрлуулдаг. Чингэхийг “Байр хийх” гэдэг байжээ. Тэгвэл орчин үед цэргийн анги, салбаруудыг байлдаанд гүйцэтгэх үүргийнх нь дагуу цувраажуулан байрлуулж байлдаанд бэлэн болгохыг “Байлдааны журам” гэж нэрлэдэг. Тэгэхээр зарчмын хувьд эртний тэрхүү “Байр хийх” болон өнөөгийн “Байлдааны журам” гэдэг ойлголт ижил болж таарч байна.

“Лу.Алтан товч”, Саган сэцэний “Эрдэнийн товч” болон бусад монгол сурвалж бичигт “Нуман түлхүүр байр”, “Жаран нэгэн бух сэжүүр байр”, “Их байр”, “Байр морин”, “Байрлалдах” гэхчилэн “Байр” хэмээхтэй холбоотой олон нэр томъёо тодорхой тэмдэглэгдсэн байна. Ер нь “Байлдах”, “Байрлалдах”, “Байр хийх” буюу “Байр” гэдэг нь эрт цагт цэргийн ухагдахууны хувьд нэгэн ижил утга санааг илэрхийлж байсан нь тодорхой байна.

⁵ Ш.Гаадамба. Монголын нууц товчоо. Худам (Язгуур эртний) монгол бичгээр сэргээсэн сийрүүлэг эх, тайлбар. Улаанбаатар. 1990 он. 364 дэх тал

⁶ Д.Цэрэнсодном. Монголын нууц товчоо. Эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар, Улаанбаатар. 2000, т. 118.

Тиймээс МНТ-нд дурдагдаж буй дээрх зүйл нь **“Нуур байр”** гэсэн тактикийн арга буюу одоогийн цэргийн хэллэгээр тийм нэртэй **“Байлдааны журам”** байсан болов уу гэх таамаглалыг эрхгүй төрүүлж байгаа юм.

Тэгэхээр **МНТ-ны §195-д буй тэрхүү томъёоллыг “Нуур байрт байлдаж” хэмээн сэргээх нь зүйтэй болов уу хэмээх саналыг бид дэвшүүлж байна.** Тактикийн эл аргын агуулгын хувьд Ш.Гаадамба гуайн дээр дурдсан тодорхойлолт бусдаас илүү оновчтой болсон гэж үзэж байна.

3. Үйсэн хор уу, хоромсого уу?

“МНТ”-ны 230 дугаар зүйлд “Үйилсэн хор убис кикүй-дүр” хэмээсэн⁷ нэгэн мөр байдгийн **“Үйилсүн хор”** гэдэг нэрийн тухайд судлаач эрдэмтэд олон янзын тайлбар хийж, өөр өөрсдийн таамгийг дэвшүүлжээ.

Үүний “Үйилсүн” буюу “Үйлсү” хэмээх нь одоогийн бидний “Үйс” гэдэг үг. “Монгол үгсийн язгуурын толь”-д ч “Хусны торос, уд үйс буюу тоос ч гэдэг”⁸ гэж тайлбарлажээ. Эл үгийн хадмал хятад орчуулга нь ч “Хус модны холтос” гэсэн утгатай байна.

Өгүүлж буй “Хор” гэдэг нь харвах зэвсгийн нэр. Өөрөөр хэлбэл хүн, амьтныг оночихоороо хор болдог, хорлодог гэсэн утгаас үүдсэн нэр. Эрт цагийн монголчууд байлдаанд хэрэглэх сумынхаа зэвэнд хүчтэй хор түрхэн харвадаг байсан агаад тийм хортой зэвээр бол заавал нарийн хараалж амин газар онох гэхийн ч шаардлагагүй, зөвхөн шалбалж шархлуулах төдий болоход л дайсан этгээдээ жагсаалаас гаргаж дөнгөдөг байсан байна. Тэгэхээр эл “Хор” гэдэг зэвсгийн нэрийн үүсэл гарваль үүнтэй ч бас холбоотой биз.

“Хор” хэмээх үгийн зэр зэвсэгтэй холбоотой өөр нэг салаа утга нь бас “Арьсан саадгийн дотор этгээд дор хавсран хадаж, годил, сэрээ дүрэхүй” савыг илэрхийлдэг⁹. Өөрөөр хэлбэл арьсан саадгийг бүрдүүлэгч нэгэн эд хэсгийнх нь нэр.

Харин “Үйилсүн хор” хэмээх оноосон нэрийн хувьд бол “Монголын нууц товчоо”-ны хятад үсгийн эхийг баримтлан Т.Дашцэдэн, Э.Хэниш, П.Пеллио, Л.Лигети, Баяр, Иринчин, Шонхор нарын олон эрдэмтэн “Хус модны үйсэн буюу үйилсүн” сум, “Үйилсүн хор” гэж сэргээж, Элдэндэй Ардажав “Үйсээр хучсан сум” гэсэн тайлбар хийжээ¹⁰.

Гэтэл зарим судлаач, тухайлбал Ш.Гаадамба гуай хүртэл: “...үйсээр хийсэн сум байж болно гэдэг их л эргэлзээтэй зүйл юм...өөр нэг санал таамаг байж болмоор санагдана. Энэ үгийн ...дараах бадагт гарч буй “Хутун хор” гэснийг Хэниш, Элдэндэй Ардажав нар “уд” (бургас) модоор сумын мөлс буюу мөс хийсэн сум гэжээ. Тиймээс энэ бадгийн үйлсүн гэдэг нь бас сумын мөс (мөгсү) хийдэг нэг өөр модны нэр, тухайлбал “гүйилэс (жимсний)-ун хор” гэж байсныг XIV зууны монгол хэлний аялгуунд “үйи[э]сүн хор” гэж тэмдэглэсэн юм биш биз гэсэн санаа төрж байна. Энэ санаа нэгд: энэ үгийг Лувсанданзан “[г]үйлэсүн” гэж

⁷ Ш.Гаадамба. Монголын нууц товчоо. Худам (Язгуур эртний) монгол бичгээр сэргээсэн сийрүүлэг эх, тайлбар. Улаанбаатар, 1990, §230.

⁸ Сэцэнцогт. Монгол үгсийн язгуурын толь, Хөх хот, 1988, т.474.

⁹ Шагж. Монгол үгний тайлбар толь, Бээжин, 1994, т.419.

¹⁰ Монголын нууц товчоон, Элдэндэй Ардажав, Сийрүүлэл тайлбар, Хөх хот, 1986, т.751.

бичсэнээс; хоёрт: гүйлс гэдэг үгийг хуучин бичигт “гүйилэсү-жимс” гэж байгаа зэрэг шалтгаанаас төрөгдөж байна” гээд “Жич (бас) “гүйилэсүн шир-а-өнггэ” гэсэн өнгө байх тул “гүйилэсүн хор” гэдэг үг бас “гүйлсэн шар сум” гэсэн үг байж ч болох юм” гэжээ¹¹.

Үүний нэгэн адил, үйсээр сум хийх нь эргэлзээтэй санагдсан уу, эсвэл дээр эши татсанчлан наадам тэмцээн, ан гөрөөнд хэрэглэдэг годил, сэрээ сум зэргийг бусад (байлдааны) сумтайгаа үл холилдуулах зорилгоор “саадагт тусад нь тасалгаа гарган хавсран хаддаг, уут сав”-ны нэрийг мөн “Хор” гэдэг болоод ч тэгсэн үү, алин боловч Ц.Дамдинсүрэн гуай хүртэл “Холтсон хоромсого” (хор буюу сум биш) гэжээ¹².

Бас С.А.Козин “Берестяной сайдак”¹³, Ф.В.Кливез “Quivers of birch-bark”¹⁴, буриадаар хэвлүүлсэн Ч.Р.Намжилова “Холтоһон хормоонго”¹⁵, Мансан “Хус модон хуй (хор)” хэмээн цөм холтсон буюу үйсэн “Хоромсого” гэсэн утгаар ойлгон орчуулжээ. Хамгийн сүүлд л гэхэд академич Д.Цэрэнсодном “Монголын нууц товчоо”-ны эрдэм шинжилгээний орчуулга, тайлбартаа мөн л “Үйсэн хоромсого” гэжээ¹⁶.

Уг нь хоромсого, хор хоёр огт ондоо зүйлс бөгөөд хоромсого бол нумыг агуулдаг уут савны нэр. Анхлан нум, сум (хор) хоёрыг нэгэн саванд агуулж явдаг, түүнийгээ хор агуулдаг сав буюу “Хоромсого” гэж нэрийдэж асан тэр эрт цагаас уламжлалтай агаад хожим нь хороо (сумаа) нумнаасаа тусад нь агуулах болсон хэдий ч эртний тэр л нэрээрээ нэршин үлдсэн зүйл. “Хор” хэмээхийн тухайд дээр тодорхой өгүүлсэн.

Нөгөө талаар хоромсогог хэзээ ч үйсээр хийдэггүй байсан агаад ямар ч атугай одоогоор “Үйсэн хоромсого” юмуу үйсээр хийсэн хоромсогони тасархай байж магадгүй гэх таамаг дэвшүүлчихээр ямар нэг зүйлийн өөдөс ч олдоогүй байгаа юм. Олдох ч үгүй биз.

Тэгэхээр эл “Үйилсүн хор”, “Гүйлсэн хор”, “Үйлсэн хоромсого” гэхчилэн олон янзаар сэргээн бичиж буй нэрийн чухам аль нь зөв вэ? гэсэн асуулт гарч ирж байна. Хариултыг хаанаас олох вэ?

Тунгаан эрэгцүүлвээс дээрх эрдэмтэд “Монголын нууц товчоо”-г гол төлөв хэлний талаас нь судлаад ийм үр дүнд хүрсэн байх бөгөөд эл үүднээс авч үзвээс энэ, тэр нь зөв, эсвэл буруу гэх арга үгүй болж байна. Тиймээс гагцхүү өөр талаас нь хандаж, өөр эх сурвалж хайх хэрэгтэй болж байгаа юм. Гэтэл тийм ч их алс холоос эрх хэрэггүй байсан ажээ. Юун гэвээс Буриадын Харбаян буюу одоо “Окошки” хэмээн нэрлэх болсон Өвөрбайгалын нэгэн уулнаа малтсан XIII зууны үеийн нэгэн монгол булшнаас мөсийг нь хусны нимгэн үйсээр туушид нь

¹¹ Ш.Гаадамба. Монголын нууц товчоо. Худам (Язгуур эртний) монгол бичгээр сэргээсэн сийрүүлэг эх, тайлбар. Улаанбаатар, 1990, т. 385-386.

¹² Ц.Дамдинсүрэн. (Хуучин монгол хэлнээс одоогийн монгол хэлээр орчуулсан орчуулга). Улаанбаатар, 1947, т.226.

¹³ Сокровенное сказание монголов. Пер. С.А.Козина. Улан-Удэ, 1990, с.115.

¹⁴ The Secret History of the Mongols. Translated and edited by F.W.Cleaves. London, 1982., p.169

¹⁵ Монголой нюуса тобшо. Ч.Р. Намжиловой оршуулга. Улан-Удэ, 1990, с.133.

¹⁶ Д.Цэрэнсодном. Монголын нууц товчоо (Эрдэм шинжилгээний орчуулга, тайлбар). Улаанбаатар, 2000, т.153.

хулдаж бүрсэн, 40-60 см-ын урттай 10-аад сум гарсан байна¹⁷. Эдгээр нь мөнөөх Элдэндэй Ардажавын “Үйлсээр хучсан сум” гээч яахын аргагүй мөн болж таарч байгаа юм. Өөрөөр хэлбэл энэ нь “Үйсэн хор” хэмээн нэрлэж асан сум болохыг гарцаагүй нотолж буй баримт юм.

Тэгэхээр үүнээс ямар дүгнэлт хийж болох вэ? гэвэл:

Нэгдүгээрт: “Монголын нууц товчоо”-ны хятад үсгийн эхэд буй “Үйилсүн хор” гэдэг бичлэг, тайлбар нь ташаа бус, алдаагүй зөв байна;

Хоёрдугаарт: Үйилсүн хор (үйсэн сум) гэдэг нь үйсээр хийсэн сум гэсэн үг биш (үнэхээр ч үйсээр хэрхэн сум үйлдэж болох), харин мөс буюу ишийг нь нимгэн үйсээр бүрсэн сум байжээ гэж үзэх бүрэн үндэстэй байна.

Тиймээс “Гүйлсэн хор”, “Үйсэн хоромсого” гэхчлэн олон янзаар бичилгүй, ямар ч эргэлзээгүйгээр “Үйилсүн хор” (Үйсэн хор) хэмээн тогтох нь зүйтэй гэж үзэж байна.

Дүгнэлт

Хэдийгээр хэл шинжээчид МНТ-ны талаар нөр их судалгаа хийж үр дүнг нь олны хүртээл болгож байгаа ч цэргийн хэргийн холбогдолтой цөөнгүй үг хэллэг, оноосон нэр, ухагдахуун одоог хүртэл оновчтой тайлбар тайллаа хүлээсээр л байгаа билээ. Үүний жишээ нь дээрх гурван нэр томъёо болж байна.

Тиймээс энэ мэт зөвхөн цэргийн түүхтэй холбогдолтой төдийгүй ерөөсөө тусгай мэргэжлийн холбогдолтой зүйлсийг зөвхөн хэлний талаас нь хөөж тайлбарлах нь өрөөсгөл бөгөөд гагцхүү олон шинжлэх ухааны уулзвар дээр, тэдгээрийн ололт амжилтад тулгуурлан судалвал учир начин нь хялбар олдох нь дамжиггүй хэмээнэ.

Abstract: *Although some linguists have published a great amount of analyses on the Secret History of the Mongols, meanings of some military terms and concepts in this historical source are still vague. Three terms being considered here are its example. It is one-sided to explain from a linguistic point of view any term and idea relevant not merely to military history but also to specialized profession. It is certain that we can give more objective interpretation if we study them from an inter-disciplinary perspective.*

¹⁷ Худяков Ю.С. Вооружение Центрально-Азиатских кочевников в эпоху раннего и развитого средневековья. Новосибирск, 1991, с.125.